



УЛСЫН ГАЗАРЗҮЙН ХХVІІІ ОЛИМПИАД

ІХ анги (дадлага)

Улаанбаатар хот
2024.04.03-05



Хугацаа: 180 минут

Нийт оноо: 40

Шифр.....

Даалгавар 1. Мултимедиа тест дээр ажиллах (Нийт 10 оноо).**Даалгавар 2.** Өгөгдсөн зургийг ашиглаад дараах бодлогуудыг бодно уу (Нийт 4 оноо).

А. Зургийн масштабыг тодорхойлоорой (1 оноо).


Б.Зургийн масштабын нарийвчлалыг тодорхойлоорой (1 оноо).

В. Зурагт үзүүлсэн Алаг Эрдэнэ уул ($H_1=1187.2\text{м}$) болон Намнан уул ($H_2=1280.5\text{м}$) хоёрын шулуун зайг тодорхойлно уу (1 оноо).

Г. Эдгээр цэгүүдийг холбосон шулууны налуугийн өнцгийг тооцно уу (1 оноо).


L-49-3-A (өлзийт)

Сургалтанд зориулав





Даалгавар 3. Газарзүйн зураг ба аялагчдын фото зургийг ашиглан даалгаврыг гүйцэтгэнэ үү (Нийт 6 оноо).




Зураг 1. Дэлхийн газарзүйн зураг

А. Хэн гэдэг аялагчийн экспедицийн замналыг харуулсан байна вэ? Аялагчийн нэрийг (хөрөг зургаас) дугуйл.



В.В. Юнкер



Марко Поло



Александр Маккензи

Б. Экспедицийн аялсан эх газрыг нэрлэ.

Хариулт: _____




В. Зурагт үсгээр тэмдэглэсэн газарзүйн юмсыг (хоолой, далай, булан, арал) нэрлэж, хүснэгтийг бөглө.

А	Б	В	Г

Г. Зурагт “З” тоогоор тэмдэглэсэн цэгийг (арал) нэрлэж, газарзүйн солбицлыг тодорхойл.

Хариулт: _____

Д. Африкийн гадаргын хөндлөн зүсэлтийг зураг 2-т үзүүлэв. Зураг 1 ба 2-ыг ашиглан Африкийн нутаг дэвсгэр дээр татсан 3 хэрчмийн аль нь дээрх хөндлөн зүсэлтийг илэрхийлэх вэ? Ямар зэргэд вэ?



Зураг 2. Африкийн хөндлөн зүсэлт

Хариулт: _____

Е. Тухайн зэргэдийн дагуух бодит зайг хүснэгтээс ол.

Өргөрөг	0°	10°	20°	30°	40°	50°	60°	70°	80°	90°
1° зэргэдийн нумын урт, км	111,3	109,6	104,6	96,5	85,4	71,7	55,8	38,2	19,4	0

Хариулт: _____



Даалгавар 4. А. Хүснэгт 1-ийг ашиглан голын урсцын графикийг хавсралт мм-ийн хуваарьтай цаасан дээр байгуулна уу (**Нийт 10 оноо**).

№	Урсцын сарын хуваарилалт, %											
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
1	22	23	6	4	3	3	2	1	1	3	8	24
2	3	2	2	1	3	24	26	23	6	4	3	3
3	12	11	7	7	8	7	6	7	8	8	10	9
4	4	4	8	27	23	7	5	4	3	6	5	5

Б. Байгуулсан графикаа ашиглан ямар хэв шинжийн гол болохыг тодорхойлно уу (Хүснэгт 2).

№	Голын урт, км	Үнэмлэхүй өндөр		Тэжээлийн эх үүсвэрийн эзлэх хувь			
		Эх	Адаг	Гүний усны	Цасны	Борооны	Мөсөн голын
1	1200	4260	420	7	0	68	25
2	3720	1240	0	8	0	82	0
3	4250	5110	0	28	0	62	10
4	860	1080	140	24	62	14	0


В. Хүснэгт 2-ыг ашиглан голын унал ба хэвгийг тооцоолно уу.

№	Голын унал, м	Хэвгий
1		
2		
3		
4		

**Даалгавар 5. Даалгаврыг гүйцэтгэнэ үү (Нийт 10 оноо).**

А. Хүснэгтийг ашиглан өгөгдсөн 2 оны хүн амын суваргыг харьцуулан байгуулаарай. (Таних тэмдгийг ашиглан)

Нас	2000 он			2022 он		
	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
0-4	246,023		121,541	354,313	181,491	
5-9	285,664		141,349	393,021	201,803	
10-14	317,434		158,140	359,331	183,451	
15-19	263,358		130,031	253,390	129,198	
20-24	235,751		117,728	227,063	115,372	
25-29	216,652		108,690	241,548	121,586	
30-34	187,872		95,399	289,957	144,816	
35-39	172,606		87,760	291,445	144,243	
40-44	127,220		64,601	239,615	116,965	
45-49	82,888		42,326	215,653	102,876	
50-54	57,835		30,128	184,239	85,818	
55-59	55,895		28,516	155,235	69,861	
60-64	42,292		21,514	125,423	53,798	
65-69	35,110		18,757	78,538	31,758	
70+	49,577		29,005	95,970	35,239	
Бүгд	2,376,177	1,180,692	1,195,485	3,504,741	1,718,275	1,786,466





Б. Суваргыг ашиглан хүн амын өөрчлөлийн шалтгааныг бичээрэй.

В. Хүн амын суваргыг өсөлтийн үе шатыг харуулсан зурагтай харьцуулж Монгол улс хэддүгээр үе шатанд хамрагдаж байгааг тодорхойлж, нөлөөлж буй голлох хүчин зүйлсийг бичнэ үү.

